



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 1 дүгээр сарын 15 өдөр      Дугаар 04

Хэрлэн сум

IV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 4 дүгээр хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 79,2 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Дэн буудал, спорт заалыг тусгаарлах байраар ашиглах боломжтой эсэх талаар хяналт, шалгалт зохион байгуулсан мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар

2.Малын вакцины хэрэглээ ашиглалтын талаар хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан мэдээлэл танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газар

3.Баянтумэн сумын нутагт шатахуун тээвэрлэсэн автомашин осол гаргаж хөрсөн дээр шатахуун асгарсантай холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газар

4.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.1.Хяналт, шалгалтаар тусгаарлах байраар ашиглах боломжтой гэж дүгнэгдсэн "Сод" дэн буудлын захиралтай урьдчилсан байдлаар гэрээ байгуулж тусгаарлах байрны нөөцөд авч ажиллахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

/   
/   
/ M.Бадамсүрэн  
/ Г.Нармандах

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Биеийн тамир спортын газрын дарга Б.Чимэддорж нарт:

1.2. Аймгийн шигшээ багуудын бэлтгэл сургуулилт хийх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Биеийн тамир спортын газрын спорт зааланд халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, 1 танхимд 10-аас ихгүй хүнтэй байх, халуун үзэж халдварт гүйжүүлэлт хийж үйл ажиллагааг эхлүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

1.3. Спорт заал тусгаарлан ажиглах байрны эрэмбэд байгаа тул Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг спорт заалуудад гэрэлтүүлэг, агааржуулалт, хувцас солих өрөө, ариун цэврийн өрөөний асуудлыг шийдвэрлэх тухай Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж бэлэн байдлыг хангуулан аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Хоёр. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,  
сумын Засаг дарга нарт:

2.1. Холбогдох стандарт, дүрэм журмын дагуу мал, амьтны вакцины савыг устгах, дахин ашиглахад хяналт тавьж ажиллахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа,  
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Аюушмаа нарт:

2.2. Мал амьтны вакцины савыг устгах, дахин ашиглах стандарт, дүрэм журмыг мөрдөж алдаа гаргахгүй ажиллах тухай албан бичгийг мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж, ахуй нэгж байгууллагуудад хүргүүлэхийг,

Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,  
Баянтумэн сумын Засаг дарга Ф.Энхтувшинд-д:

3.1. Баянтумэн сумын нутаг дэвсгэрт шатахуун тээвэрлэсэн автомашин осолдсоны улмаас байгаль орчинд үүссэн хохирлыг тус компанийас нэхэмжлэн нөхөн төлүүлэхийг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа-д:

3.2. Баянтумэн сумын нутагт шатахуун тээвэрлэсэн автомашин осол гарсантай холбогдуулан тухайн компанийд хүргүүлсэн албан шаардлагын биелэлтийг хангуулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга,

/  / М.Бадамсүрэн  
/  / Г.Нармандах

Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг,  
Гэр бул, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын  
дарга Э.Жавхлан нарт:

3.3. Олон нийтийн газраар хүүхэд авч явахгүй байх талаар санал боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Дөрөв. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа.

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах.

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг.

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

4.1. Жолооны курс, дамжаа бусад сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил зохион байгуулах, дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа.

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг.

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа.

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

4.2. Дорнод аймгаас Улаанбаатар хот руу зорчих хүсэлт гаргасан, хүндэтгэн үзэх шалтгаантай иргэдийг 1 автобусаар 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж зорчуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах.

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг.

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
хурандаа Б.Бямбаа нарт:

4.3. Аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабын бүрэлдэхүүнд Цагдаагийн газар, Тагнуулын газрын дарга нарыг нэмж оруулах,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах.

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:

4.4. Аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабын үйл ажиллагааг зохион байгуулах, ажиллах боломжоор хангах зорилгоор шаардлагатай тоног

/  / М.Бадамсүрэн  
/  / З.Ганжигмид

төхөөрөмж, шатахуун бусад зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

4.5. Аймгийн төвд ачаа, бараа буулгахад хяналт тавьж буй Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагч нарын үүрэг гүйцэтгэхэд гарах зардлыг, гүйцэтгэлээр тооцож аймгийн Засаг даргын нөөцийн сангаас шийдвэрлүүлэхийг,

4.6. Аймгийн төвөөс бусад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж, ахуй нэгж байгууллагын хүсэлтээр Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагч хяналт тавих зорилгоор ажилласан тохиолдолд албан томилолт, шатахууны зардлыг тухайн аж, ахуй нэгж байгууллагаас шийдвэрлүүлж байхыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

4.7. Хот хоорондын хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан зөрчил гаргасан иргэний тээврийн хэрэгсэл, бараа материалыг дулаан гражд ариутгал халдвартгүйжүүлэлт хийх, буруутай эдгээдээр гарсан зардлыг нөхөн төлүүлэхийг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбат,  
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

4.8. Зөрчил гаргасан иргэний тээврийн хэрэгсэл, бараа материалд ариутгал халдвартгүйжүүлэлт хийх боломжтой дулаан граж судалж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Тав. Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга,  
дэд хурандаа Л.Эрдэнэбат нарт:

5.1. Цагдаагийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Улаанбаатар хот руу яллагдагч зөөврөлөх, хүлээн авах тухай" хүсэлтийн дагуу З албан хаагчийг руу яллагдагч зөөврөлөх, хүлээн авах тухай" хүсэлтийн дагуу З албан хаагчийг нэвтрүүлж, бэлтгэсэн тусгаарлан ажиглах байранд тусгаарлах, халдварт гамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

/  / М.Бадамсүрэн  
/  / Ганзориг

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

5.2. Цагдаагийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Улаанбаатар хот руу албан ажлаар нэвтрэх" хүсэлтийн дагуу 3 албан хаагчийг нэвтрүүлж халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.3. Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Зөвшөөрөл олгох тухай" хүсэлтийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын албан ажлын талаар Улсын Онцгой комиссоос тодруулж танилцуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

5.4. Иргэн Б.Соёлчхүүгээс аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Жудо бөхийн клубын үйл ажиллагааг эхлүүлэх тухай" хүсэлтийн дагуу мэргэжлийн байгууллагын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж хяналт, шалгалтыг зохион байгуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

5.5. Улаанбаатар төмөр замын Баянтумэн тасгаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Төмөр замын дэр мод татах" хүсэлтийн дагуу жолоочийг бэлтгэсэн тусгаарлан ажиглах байранд тусгаарлах, халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

5.6. "Петрочайна дачин тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Улаанбаатар хот руу БНХАУ-ын иргэн 4 ажилтанг нэвтрүүлэх" хүсэлтийн дагуу халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

5.7. "Петрочайна дачин тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Тосон-Уул 19 дүгээр талбайгаас ээлж солих 2 ажилтанг Улаанбаатар хот руу нэвтрүүлэх" хүсэлтийн дагуу халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэхийг зөвшөөрөв,

/  / М.Бадамсүрэн  
/  / Т.Ганзориг

5.8."Петрочайна дачин тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Тамсаг 21 дүгээр талбайгаас ээлж солих 4 ажилтанг Улаанбаатар хот руу нэвтрүүлэх" хүсэлтийн дагуу тээврийн хэрэгслийг тодруулж аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабт шийдвэрлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.9."Петрочайна дачин тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Өвдөг-Баянхошуу боомтоор бараа материал оруулах" хүсэлтийн дагуу Улсын Онцгой комисст албан бичгээр уламжлахыг,

Онцгой комиссын нийт гишүүд,  
сумдын Засаг дарга нарт:

5.10.Зам тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтран баталсан "Мал, мах өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тээвэрлэлтийг хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай" тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус тус үүрэг болгов.

